



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2025 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 276

Улаанбаатар хот

「 Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.2.5, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 3,421,624,840.00 (гурван тэрбум дөрвөн зуун хорин нэгэн сая зургаан зуун хорин дөрвөн мянга найман зуун дөх) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан цахилгаан соронзон давтамжит оношилгооны аппарат MRI-г иж бүрдлээр нь акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирал, хошууч Н.Одонгуа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т уурал болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



133001349
12-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2025 оны 02 дүгээр сарын 30-ны өдрийн
2.46 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ХААГЧДЫН НЭГДСЭН ЭМНӨЛГИЙН ҮНДСЭН
ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГӨ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон, капиталжуулан бүртгэсэн он	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо шир хэг	Балансын нийт үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	Цахилгаан соронзон давтамжит оношлогооны аппарат-MRI (Brivo MRI355 1.5T, иж бүрдэл)	2012/2021	3,421,624,840.00	1	3,421,624,840.00
	Нийт дүн				3,421,624,840.00 (гурван тэрбум дөрвөн зуун хорин нэгэн сая зургаан зуун хорин дөрвөн мянга найман зуун дөч)